



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Долоошар заг ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/045/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 299
танай _____ -ны № _____ -т

ДОЛООШАР ЗАГ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ШИНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Долоошар заг ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянга, өөрийн хөрөнгөөр 3,163.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад 46,247.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050428

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө		
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,242,952.58	155,558.73
4	Дансны авлага	-	-
5	Татвар, НДШ-ийн авлага	-	-
6	Бусад авлага	-	-
8	Бараа материал	25,713,234.48	34,461,242.86
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,956,187.06	34,616,801.59
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө барилга	3,658,872,033.33	3,488,619,654.07
23	Биет бус хөрөнгө	10,536,250.18	10,273,750.18
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,669,408,283.51	3,498,893,404.25
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,697,364,470.57	3,533,510,205.84
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
27	Өр төлбөр		
28	Богино хугацаат өр төлбөр		
29	Дансны өглөг	-	-
30	Цалингийн өглөг	-	-
31	Татварын өр	15,056,388.03	50,229,567.43
32	НДШ-ийн өглөг	16,780,538.69	20,100,000.00
33	Богино хугацаат зээл	-	-
36	Урьдчилж орсон орлого	-	-
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,836,926.72	70,329,567.43
42	Урт хугацаат өр төлбөр		
43	Урт хугацаат зээл	-	-
46	Бусад урт хугацаат өглөг	3,468,003,978.09	3,302,432,762.41
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,468,003,978.09	3,302,432,762.41
49	Өр төлбөрийн нийт дүн	3,499,840,904.81	3,372,762,329.84
50	Эздийн өмч		
51	Өмч: а) төрийн	414,198,358.33	414,198,358.33
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,082,920.20	19,082,920.20
58	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	78,063,775.00	78,063,775.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(313,821,487.77)	(350,597,177.53)
61	Эздийн өмчийн дүн	197,523,565.76	160,747,876.00
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,697,364,470.57	3,533,510,205.84

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	659,221,758.63	516,166,213.22
2	Борлуулалтын өртөг	540,299,371.86	706,189,536.14
3	Нийт ашиг	118,922,386.77	(190,023,322.92)
8	Бусад орлого	-	241,770,904.41
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	116,121,391.81	88,523,271.25
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,800,994.96	(36,775,689.76)
19	Орлогын татварын зардал	280,099.49	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	2,520,895.47	(36,775,689.76)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,520,895.47	(36,775,689.76)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Орлогын нийт дүн	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(313,821,487.77)	197,523,565.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	(36,775,689.76)	(36,775,689.76)
2025 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(350,597,177.53)	160,747,876.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	599,006,997.27	656,159,925.55
8	Бусад мөнгөн орлого	599,006,997.27	656,159,925.55
9	Мөнгөн зарлагын дүн (-)	597,529,997.85	658,247,319.40
10	Ажиллагчдад төлсөн	251,395,077.00	290,724,657.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	58,381,401.31	88,006,540.17
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	114,652,289.35	104,317,800.00
13	Ашиглалтын зардалд төлсөн	33,603,946.43	45,464,114.15
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	85,796,300.66	100,249,169.25
16	Татварын байгууллагад төлсөн	53,700,983.10	29,485,038.83
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,476,999.42	(2,087,393.85)
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
21	Мөнгөн орлогын дүн (+)		
22	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
30	Мөнгөн зарлагын дүн (-)		
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
39	Мөнгөн орлогын дүн (+)		
40	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
41	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
42	Төрөл бүрийн хандив	-	-
44	Мөнгөн зарлагын дүн (-)		
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
47	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
48	Төлсөн ногдол ашиг	-	-
49	Бусад зарлага	-	-
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
51	Валютын ханшийн зөрүү	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,476,999.42	(2,087,393.85)
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	765,953.16	2,242,952.58
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,242,952.58	155,558.73

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны төлөвлөгөө	2025 оны нийт гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулааны мөнгөн орлого	515,759,790.00	516,166,213.22	406,423.22	100.1
2	Бусад орлого	3,263,500.00	3,706,800.00	443,300.00	113.6
3	Үнэ төлбөргүй орсон үндсэн хөрөнгийн орлого /элэгдэл/	166,708,900.00	185,234,233.41	18,525,333.41	111.1
4	Нутгийн дэм	52,690,000.00	52,829,871.00	139,871.00	100.3
Нийт орлого		738,422,190.00	757,937,117.63	19,514,927.63	102.6
1	Цалин	312,534,882.00	312,837,050.58	302,168.58	100.1
2	НД-ийн шимтгэл АО-с	45,125,678.55	43,420,649.06	(1,705,029.49)	96.2
3	Нутгийн дэм	46,400,000.00	45,939,369.00	(460,631.00)	99.0
4	НД-ийн шимтгэл АО-с	6,995,000.00	6,752,677.26	(242,322.74)	96.5
5	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	193,678,515.26	191,334,072.09	(2,344,443.17)	98.8
6	Шатахууны зардалд	26,855,000.00	26,386,766.07	(468,233.93)	98.3
7	Нүүрс тээврийн хөлс	54,100,000.00	53,761,235.02	(338,764.98)	99.4
8	Үнс тээврийн зардал	1,800,000.00	1,777,777.00	(22,223.00)	98.8
9	Хөдөлмөр хамгаалал	12,936,500.00	12,382,850.55	(553,649.45)	95.7
10	Албан томилолт	3,000,000.00	2,980,000.00	(20,000.00)	99.3
11	Сургалтын зардал	2,500,000.00	2,299,709.00	(200,291.00)	92.0
12	Цахилгааны зардал	41,680,000.00	41,331,013.18	(348,986.82)	99.2
13	Шуудан холбооны	200,000.00	95,454.00	(104,546.00)	47.7
14	Бичиг хэргийн зардал	2,500,000.00	2,000,054.20	(499,945.80)	80.0
15	Уурын зуухны тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээ	23,000,000.00	38,336,685.59	15,336,685.59	166.7
16	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ	1,000,000.00	1,344,443.17	344,443.17	134.4
17	Шагнал урамшуулал	1,600,000.00	-	(1,600,000.00)	-
18	Бусад	5,000,000.00	4,907,599.63	(92,400.37)	98.2
19	Хог хаягдлын зардал	60,000.00	60,000.00	-	100.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж бусад татвар	4,500,000.00	4,855,443.00	355,443.00	107.9
21	Цэвэр бохир усны төлбөр	2,000,000.00	1,909,955.99	(90,044.01)	95.5
Зарлагын дүн		787,465,575.81	794,712,804.39	7,247,228.58	100.9
Татварын өмнөх ашиг /алдагдал/		(49,043,385.81)	(36,775,686.76)	12,267,699.05	75.0
Орлогын татвар		-	-	-	-
Цэвэр ашиг		(49,043,385.81)	(36,775,686.76)	12,267,699.05	75.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 190.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад 190.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд хойшлогдсон орлого 185.6 сая төгрөгийг бусад орлогоор тусгаагүй;
- Цалингийн өглөг дансыг цалингийн тооцоололтой тулган баталгаажуулахад 1.2 сая төгрөгөөр дутуу тусгасан;
- Бараа материалын түүвэр тооллогоор байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 3.5 төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалаар бүртгэсэн байна.

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6.4 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 0.3 сая төгрөгийн хөрөнгийн код зөрсөн, 3.2 сая төгрөгийн хөрөнгийг коджуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна. 2-т Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна." гэж заасныг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг коджуулах, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Илрүүлэлт 2: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаал "Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгож, дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орлогын дэлгэрэнгүй тайланд хойшлогдсон орлого 185,571.2 мянган төгрөгийг бусад орлогоор тусгаагүй.	1	188,571.2	-	-	1	188,571.2	1	188,571.2	-	-	-	-
2	Цалингийн өглөг дансыг цалингийн тооцоололтой тулган баталгаажуулахад 1,202.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	1	1,202.4	-	-	1	1,202.4	1	1,202.4	-	-	-	-
3	Бараа материалын түүвэр тооллогоор байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 3,510.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалаар бүртгэсэн	1	3,510.0	-	-	1	3,510.0	1	3,510.0	-	-	-	-
	Дүн	3	193,283.6	-	-	3	193,283.6	3	193,283.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 318.2 мянган төгрөгийн хөрөнгийн код зөрсөн, 3,163.6 мянган төгрөгийн хөрөнгийг коджуулаагүй.	1	3,481.8	-	-	-	-	1	3,481.8	-	-	-	-
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй бүртгэсэн.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	2	3,481.8	-	-	-	-	2	3,481.8	-	-	-	-